



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/286

Баруун-Урт сум

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 10 дугаар зүйлийн 10.1,3, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Эрдэнэцагаан сумын Ц.Амаржаргал захиралтай “Хутагт уулын говь” ХХК-ийн “Од” хүнсний дэлгүүрт шинээр зөвшөөрөл олгох, Эрдэнэцагаан сумын 8-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй С.Эрдэнэтуяа захиралтай “Гэгээн-Арвижих” ХХК-ийн “Номин” хүнсний дэлгүүр, О.Мөнхцэцэг захиралтай “Сод дэвших” ХХК-ийн “Номин-Эрдэнэ” хүнсний дэлгүүр, Баяндэлгэр сумын 6-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Ариунзаяа захиралтай “Мөнгөн болор шагай” ХХК-ийн “Аз” хүнсний дэлгүүр, Дарьганга сумын 4-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Л.Болорчулуун захиралтай “Дарьганга болор чулуут” ХХК-ийн “Болор-1” хүнсний дэлгүүр, “Болор-2” хүнсний дэлгүүр, Наран сумын 3-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй М.Энхмаа даргатай Наранзаяат ЗГБХНөхөрлөлийн “Наран заяат” хүнсний дэлгүүр, Сүхбаатар сумын 2-р багийн нутаг дэвсгэр үйл ажиллагаа явуулж буй Ц.Ган-Өлзий захиралтай “ГЦТБ” ХХК-ийн “Хайлааст үүдэн” хүнсний дэлгүүр, Баруун Урт сумын 1-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Эрдэнэбаатар захиралтай “Их нарт хайрхан” ХХК-ийн “Тэмүүлэл” хүнсний дэлгүүр, Баруун- Урт сумын 5-р нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Д.Мөнхгэрэл захиралтай “Ариуннандин жаргал” ХХК-ийн “Хан Хөхий” хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 2-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Болор захиралтай “Дарьганга катеринг” ХХК-ийн “Дарьганга” зоогийн газар, Дарьганга сумын 4-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Г.Адъяа захиралтай “Баян Дарьганга Брэнд” ХХК-ийн “Дарьганга брэнд” хүнсний дэлгүүр, Баруун Урт сумын 4-р багийн нутаг дэвсгэр үйл ажиллагаа явуулж буй Ө.Ганзориг захиралтай “Энэрэлт баясгалан” ХХК-ийн “Every one pub”, Түвшинширээ сумын 1-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Д.Сайнсанаа захиралтай “Сорза” ХХК-ийн “Оюу” хүнсний дэлгүүр, Мөнххаан сумын 4-р багийн нутаг дэвсгэр үйл ажиллагаа явуулж буй Ш.Эрдэнэцэцэг захиралтай “Гал түшиг” ХХК-ийн “Гал түшиг” хүнсний дэлгүүр, “Бодь” хүнсний дэлгүүр, “Sky” зоогийн газрын согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 05 сарын 24-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай сунгасугай.

2. Тусгай зөвшөөрөл сунгагдсан болон шинээр олгогдсон аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Х.Энхцэцэг), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Гантулга), Мэргэжлийн хяналтын газар (С.Нямжав), Стандарт хэмжил зүйн хэлтэс (Д.Эрдэнэбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг дээрх аж ахуй нэгжүүдийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the name 'М.ИДЭРБАТ' and the title 'ЗАСАГ ДАРГА'.

М.ИДЭРБАТ